

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

**“TV9” ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ: ҮР ДҮН, ТУРШЛАГА, СУРГАМЖ**

Т.Баасансүрэн*

*“TV9” телевизийн захирал, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: телевизийн хөтөлбөр, танин мэдүүлэх үүрэг, чөлөөт хэвлэл, социологийн судалгаа, нэвтрүүлгийн хүртээмж, хөтөлбөрийн агуулга ба хэлбэр.

Монголчууд өнөөдөр өдөр тутмынхаа мэдээллийн 86 хувийг телевизийн сувгуудаас авч байна гэсэн судалгаа бий. Хэдэн жилийн өмнө эл үзүүлэлт 92 хувьтай байсан юм. Сүүлийн үед цахим сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж эхэлснээр телевиз үзэгчдийн статистикт дээрх өөрчлөлт орсон нь ойлгомжтой юм. Ийм үзэгдэл, чиг хандлага цаашид ч үргэлжилнэ. Гэхдээ телевизийн сувгуудаас мэдээлэл олж авагчдын тоо хэмжээ огцом унана гэсэн магадлал байхгүй. Учир нь телевиз өөртөө олон давуу талыг хадгалж буйд юм.

Өнгөрсөн зууны ерээд оны сүүлч, хоёр мянган оны эхээр Монголд арилжааны гэх тодотголтой хувийн телевизүүд үүссэн нь чөлөөт хэвлэлийн хөгжилд хүчтэй түлхэц үзүүлсэн юм. 1967 онд үүссэн “Монголын үндэсний телевиз”, 1983 онд байгуулагдсан “UBS” телевиз нь Монгол Улсын төр засгийн, нийслэлийн төр захиргааны байгууллагын хэвлэл мэдээллийн хэрэгсэл байсан бөгөөд

УИХ-аас 1998 онд баталсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” Монголд хэрэгжиж эхэлснээр чөлөөт телевиз, сонин, сэтгүүлүүд буй болох үүд хаалга нээгдсэн түүхтэй. Үр дүнд нь хувийн телевизүүд, хэдэн зуун сонин, сэтгүүлүүд үүссэн билээ.

Тэдний нэг нь “TV9” телевиз, өнөөдөр 15 нас хүрч байна. Би энд сүүлийн жилүүдийн зарим судалгааны үр дүнд түшиглэж санаа бодлоо илэрхийлэхийг хичээлээ. Монголд ийм судалгааг байнга хийдэг нь “Монголын Хэвлэлийн Хүрээлэн” ТББ, “MAXIMA” судалгааны компани юм. “Сант Марал” сан үе үе судалгаа явуулдаг. Монголын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) тандалтын судалгааг хийдэг. ХХЗХ-ноос 2013 онд 21 аймагт телевиз үзэгчдийн байдалд хийсэн тандалт судалгаанаас харахад “TV9” телевиз соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн үүргээ хамгийн сайн биелүүлж байгаа сувгуудын хоёрдугаарт эрэмблэгдэжээ. Хамгийн шуурхай, тэнцвэртэй мэдээлэл түгээдэг сувгуудыг “TV9” телевиз манлайлсан байна. Хамгийн сонирхолтой хөтөлбөр бэлтгэн гаргадаг үзүүлэлтээрээ тус телевиз хоёрдугаарт орж, 40-50 насны хоорондох үзэгчдийн тоогоор улсад тэргүүлсэн байна¹.

Нийт телевизийн хөтөлбөрийг бүтцийн хувьд судалж үзэхэд хамгийн олон талт мэдээлэлтэй телевизээр “TV9” телевиз шалгарчээ. Хүүхэд залуучуудын хүмүүжил, ёс суртахууны сэдэвт нэвтрүүлгийн тоо хэмжээгээрээ “TV9” телевиз хоёрт, шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлгүүдээрээ гуравт жагсч байв.

Орон нутгийн үзэгчдийн үнэлэмжийн дагуу телевизүүдийн рейтингийг тогтоож эрэмблэхэд “TV9” телевиз нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөрийн агуулга ба бүтэц, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага зэрэг долоон үзүүлэлтээр хамгийн өндөр оноог авч тэргүүлсэн байна. Тус телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөр, “Монгол коммент” шууд нэвтрүүлэг, танин мэдэхүйн “АХА”, спортын чиглэлийн нэвтрүүлгүүдийг орон нутагт хамгийн ихээр үздэгийг уг судалгаа тогтоосон байна. “МАКСИМА” судалгааны компани 2014 онд Орхон аймгийн телевиз үзэгчдийн байдалд социологийн судалгаа хийж үзэхэд 49,8 хувиар “TV9” телевиз тэргүүлжээ.

Энэ бол ХХЗХ, “МАКСИМА” судалгааны компаниас орон нутгийн үзэгчдийн дунд явуулсан телевиз үзэгчдийн судалгааны дүн бөгөөд “TV9” телевиз өнөөдөр ч уг байр сууриа хадгалсан хэвээр байна.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн 2012 оны 11, 12 дугаар сар ба 2013 оны 1, 2, 3, 4, 5 дугаар сарын судалгааны дүнгээр буюу зах зээлд эзлэх хувь хэмжээгээр “TV9” телевиз тогтмол эхний тавд, мэдээллийн хөтөлбөрийн хүртээмжээр “Энэ өдөр” хөтөлбөр 2-4-р байрт орж байв. Үүнд “TV9” телевиз нь ард түмний амин эрх ашгийг хамгаалж ямагт сөрөг хүчний хүчтэй дуу хоолой болж байдаг онцлог нь нөлөөлсөн байх үндэслэлтэйг

сэтгүүл зүйн зарим судлаач тэмдэглэжээ. Энэ нь Улаанбаатар хотын 5-6 дүүрэгт хийсэн судалгааны үр дүн юм.

Мөн сар бүр хамгийн олон үзэгчтэй мэдээллийн хөтөлбөр, хамгийн олон үзэгчтэй 30 нэвтрүүлэг, хөгжмийн болон спортын 20 нэвтрүүлэг, танин мэдэхүйн 30 нэвтрүүлэг зэргийг МХХ үзэгчдээс санал асууж шалгаруулснаас мэдээллийн болон спортын нэвтрүүлгээр “TV9” телевиз тогтмол эхний гуравт, бусад үзүүлэлтүүдээр эхний 5-10 дугаар байрт орж байв.

МХХ-гээс 2014 оны нэгдүгээр сард гаргасан Улаанбаатар хотын “Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа”-ны дүнгээр “TV9” телевиз Улаанбаатар хотын хүн амын 32%-д хүрдэг үзүүлэлтээрээ буюу хүртээмжээрээ гуравдугаар байрт оржээ. Энэ нь нэгдүгээрт орсон МҮОНТ-ээс 5 функтээр л доогуур үзүүлэлт гэсэн үг юм. Мөн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөр дээрх судалгаагаар МҮОНТ-ийн “Цагийн хүрд”-ийн дараа орж байв².

2013 оноос “МАКСИМА” компани Монгол дахь бүх телевизийн нэвтрүүлэг хөтөлбөрийн судалгааг өдөр алгасалгүй хийж эхэлсэн билээ. Тус компанийн судалгаагаар “TV9” телевиз 2013-2014 онд хамгийн олон үзэгчтэй топ таван телевизийн нэгээр нэрлэгджээ. Өнөөдөр энэ үзүүлэлт үргэлжилсэн хэвээрээ байгаа.

“МАКСИМА” судалгааны компанийн 2015 оны телевиз үзэгчдийн судалгааны нэгдсэн тайланд Монголын топ 10 телевизээс үзэгчдийнхээ тоо хэмжээгээр “TV9” телевиз дөрөвдүгээр байрт эрэмблэгдсэнийг онцолжээ. Үйл ажиллагаа нь бүтэн жилийн турш жигд үргэлжилсэн байна. Бүтэн өдрийн болон оргил цагийн рейтингээрээ 11

сарын турш эхний тавд багтсан аж. 2015 оны тавдугаар сард л нэг удаа топ аравт нэрлэгдсэн байна.

“TV9” телевизийн мэдээллийн хөтөлбөр гэхэд 2015 онд гурван улирал дараалан үзэгчдийнхээ тоо хэмжээгээр дөрөвдүгээр байрт орсон бол тус телевизийн гадаад мэдээ мөн оны 1, 4-р улиралд тус бүр зургаа дугаар байрт шалгарч байжээ.

“TV9” телевизийн зугаацуулах нэвтрүүлгүүдээс улирал тутам 2 хөтөлбөр эхний аравт орж байсан бол 2015 оны нэгдүгээр улиралд нийгэм-улстөрийн шилдэг 10 хөтөлбөрийг шалгаруулахад “TV9” телевизийн 4 нэвтрүүлэг бичигдсэн байна. Энэ бол Монголын 90 гаруй телевизийн сувгуудын үзэлтэд “TV9” телевизийн эзэлж буй байр суурь юм.

“МАКСИМА” судалгааны компанийн 2017 оны телевиз үзэгчдийн нэгдсэн тайланд тэмдэглэснээр 18.00-19.00 цаг, 19.00-20.00 цаг, 20.00-21.00 цаг, 21.00-22.00 цаг, 22.00-23.00 цаг, 23.00-24.00 цаг гэсэн 6 ангиллаар телевизүүдийн оргил цагийн рейтингийг тодорхойлоход “TV9” телевиз топ аравт тогтвортой багтаж чадсан байна. Бүтэн өдрийн үзэгчдийн тоо хэмжээгээрээ ч мөн адил эхний аравт оржээ. Энэ бол үзэгчдийн тоогоор “TV9” телевиз тэргүүлэх эгнээнд явж байна гэсэн үг юм.

Уг судалгаанаас харахад 2017 оны хамгийн олон үзэгчтэй байсан мэдээ мэдээлэл, нийгэм-улстөрийн нэвтрүүлэг, телевизийн шоу, олон ангит уран сайхны киног тус бүр эхний арван байр эзлүүлж улирал тус бүрээр гаргахад “TV9” телевизийн мэдээ мэдээллийн хөтөлбөр бүх улиралд, “Монгол коммент”, “Хасах градус” зэрэг нийгэм, улстөрийн сэдэвт нэвтрүүлэг мөн дөрвөн улирал дараалан, “Айлын

хоол амттай”, “Монгол Let me in”, “Мөрөөдөл биелдэг юм”, “АХА” зэрэг хөтөлбөр телевизийн шоу ангилалд бүх улиралд тэргүүн байранд шалгарчээ. “Дуулиан” зэрэг олон ангит кино ч шилдгээр нэрлэгдсэн байна.

Одоо “Сант Марал” сангаас 2017 оны гуравдугаар сард Улаанбаатар хот болон Завхан, Хэнтий, Архангай, Төв, Өвөрхангай, Дорноговь аймгийн 1200 иргэнийг хамруулж хийсэн “Монголчуудын хэвлэл мэдээлэлд хандах хандлагын үр дүн” судалгааны зарим үр дүнгээс сонирхуулъя. Судалгаанд оролцогчид ямар сэдвийг илүүтэй сонирхдог вэ гэсэн асуултад 67,4 хувь нь дотоодын мэдээлэл, орон нутгийн мэдээг илүүтэй анхаардгаа хэлсэн байна. Тэдгээрээс 30,3 хувь нь улстөрийн сэдэв, 29,3 хувь нь эдийн засаг, 24,4 хувь нь эрүүл мэндийн сэдэв, 16,5 хувь нь хөгжөөнт цэнгээнт үзвэрийг, 5,4 хувь нь спорт, 4,9 хувь нь урлаг, 10,9 хувь нь гадаад мэдээ, 8,2 хувь нь соёл ба ёс заншил, 3 хувь нь боловсрол, 7,3 хувь нь хоол хийх, хүнсний сэдэв гэх зэргээр хариулжээ.

Дотоодын сэдэвт мэдээ мэдээлэл, орон нутгийн үйл амьдралын мэдээг гэхэд хөдөө орон нутагт 79,2 хувь нь, нийслэлд 53,5 хувь нь үздэг аж. Улс төрийн сэдвийг хөдөө орон нутагт судалгаанд хамрагсдын 31,8 хувь үзэж байсан бол Улаанбаатарт уг үзүүлэлт 29,1 хувьтай гарчээ. Эдийн засгийн сэдэв Улаанбаатарт 30,2 хувьтай байхад хөдөө орон нутагт 29,3 хувьтай байсан аж. Эрүүл мэнд болон эрүүл амьдралын хэв маягийн сэдэв орон нутгийнхны 25,5 хувийн сонирхлыг татаж буй бол Улаанбаатарт эл сэдэв 23,5 хувьтай гарсан байна. Хөгжөөнт үзвэр, зугаацуулан цэнгүүлэх хөтөлбөр хөдөө орон нутагт 17,8 хувьтай, нийслэл хотод 15,1 хувьтай

байжээ. Араас нь спорт, урлаг, гадаад мэдээ эрэмблэгджээ.

Нийслэл Улаанбаатар хот болон 6 аймагт хийгдсэн эл судалгаа телевиз үзэгчдийн харьцангуй нийтлэг дүр төрхийг илэрхийлж байх бүрэн магадлалтай. Учир нь “Сант марал” сангаас сүүлийн 20 гаруй жилийн турш Монголын нийгмийн амьдралын янз бүрийн сэдвээр тасралтгүй явуулж ирсэн судалгааны үр дүн бодит байдлаас нэг их хол зөрдөггүй нь нэгэнт батлагдсан билээ.

“Сант Марал” сангийнхны “Та аль аль теле сувгийг хамгийн найдвартай гэж үзэж байна вэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 73,9 хувь нь МҮОНРТ, 26.8 хувь нь “TV9”, 15.4 хувь нь “Боловсрол”, 14.0 хувь нь “Монгол”, 9.5 хувь нь “Ийгл”, 7.1 хувь нь “25-р суваг”, 6.5 хувь нь “Малчин”, 4.4 хувь нь “UBS”, 4.3 хувь нь “TV5”, 3.7 хувь нь “TV8”, 2.4 хувь нь “NTV”, 2.0 хувь нь “С1” телевиз гэж хариулсан байна³.

Эндээс үүсэн байгуулагдаад 51 жил болж байгаа МҮОНРТ Монголын мэдээллийн зах зээлд үлэмж давуу байдлаа хадгалсан, хамгийн найдвартай эх сурвалж гэж итгэгдсэн хэвээр байгааг харж болно. Үүнд хагас зууны турш мэдээ мэдээллийн салбарт дангаар ноёрхож ирсэн монополь уламжлал, тэрчлэн монголчууд төр засгийн дуу хоолой болсон ХМХ-д илүүтэй итгэдэг үндэсний онцлог зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байх магадлалтай. Мэдээж төрөөс буюу татвар төлөгчдийн мөнгөөр санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлдэг, өндөр мэргэжлийн олон зуун мэргэжилтэн ажиллуулдаг, техник хэрэгслийн хангамж харьцангуй сайн, үйл ажиллагааны арвин баялаг туршлага хуримтлуулсан

зэрэг өөр цөөнгүй хүчин зүйлс үйлчилж буй нь ойлгомжтой юм.

“TV9” 23.8 хувиар хоёрдугаарт жагсчээ. 51 жил ба 15 жилийн настай олон нийтийн ба хувийн гэсэн статустай МҮОНТ ба “TV9” телевизийн харьцаа, өөрөөр хэлбэл телевиз үзэгчдийн зүгээс тэдэнд итгэл хүлээлгэж буй найдвартай хэмээх үнэлгээ ийм байна. Энэ бол муу үзүүлэлт биш. Маш сайн үзүүлэлт. Хэрэв хамгийн найдвартай гэж үзээд өөрсдийн саналаа өгсөн бусад 10 телевизийн тус бүрийн оноог “TV9”-ийн 26.8 хувь дээр нэмэх юм бол нийлбэр нь 96.1 хувь болно. Үүнийг сэтгүүл зүйн мэргэжлийн үүднээс, үйл ажиллагааны туршлага хуримтлуулсан он цагийн хугацаа зэрэг бусад хүчин зүйлийг харгалзан тооцож үзэх юм бол үнэлгээ чөлөөт телевизүүдийн талд гарна.

МҮОНРТ-ийг хамгийн найдвартай радио телевизийн суваг гэж үзэгчдийн тоо хэмжээ Улаанбаатарт 62.7 хувь, хөдөөд 83.4 хувьтай гарсан бол “TV9” телевизийн хувьд нийслэлд 23.1 хувь, орон нутагт 29.8 хувьтай гарчээ. Эл үзүүлэлт “Боловсрол” телевиз дээр Улаанбаатарт 19,1 хувь, хөдөөд 12,3 хувь, “Монгол” телевиз дээр Улаанбаатарт 23.3 хувь, хөдөөд 6.2 хувьтай, “Ийгл” телевиз дээр нийслэлд 14.9 хувь, хөдөөд 4.9 хувьтай, “25-р суваг” телевиз дээр Улаанбаатарт 6.4 хувь, орон нутагт 7.7 хувьтай, “Малчин” телевизэд нийслэлд 0,7 хувь, хөдөөд 11.4 хувьтай тус тус гарсан аж. Дээрх үзүүлэлтээс МҮОНТ ба “TV9” телевизийг хамгийн найдвартай суваг мөн гэж үзэгчдийн тоо хэмжээ нийслэл Улаанбаатар хотод харьцангуй илүү (62.7 ба 23.1 хувь), харин бусад телевизийн сувгуудад эсрэгээрээ буюу итгэл найдвар хүлээлэгчид орон нутагт

зонхилж байгааг харж болохоор байна. Нийслэлийнхэн бол бүх төрлийн мэдээлэлд хамгийн ойр, олон төрлийн мэдээ мэдээллээс сонголт хийх, харьцуулан жиших давуу талтайг энд хэлэх нь бараг илүүц буй заа.

Теле сувгуудын нэвтрүүлэг, хөтөлбөрүүдтэй холбоотой зарим тулгамдсан асуудалд “Сант Марал” сангийнхан анхаарал хандуулж тандалт хийж үзжээ. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдагсдын 95,9 хувь нь Монгол Улсын холбоотой мэдээллийг улам илүүтэй болгох шаардлагатай гэж үзсэн, хөдөө орон нутгийнхны 96,4 хувь нь үүнтэй бүрэн санал нийлж байна гэж хариулжээ. Телевизийн гол мэдээлэл бол Монголын тухай сэдэв байх ёстой гэж судалгаанд оролцогчдын үнэмлэхүй дийлэнх үзжээ.

Гадаадын улс орнуудын талаарх мэдээ мэдээллийг нэмэгдүүлэхийг Улаанбаатараас судалгаанд оролцогчдын 69,7 хувь нь дэмжсэн бол хөдөө орон нутгийнхнаас бүрэн санал нийлж байгаагаа 70,9 хувь нь илэрхийлжээ. Хөгжөөнт үзвэр, зугаацуулан цэнгүүлэх телевизийн хөтөлбөрийг нэмэгдүүлэхийг нийслэл Улаанбаатарт 54,2 хувь нь хүсч байгаа бол эл үзүүлэлт аймаг, орон нутагт 59,3 хувьтай байгаа аж.

Телевиз үзэгчдийн эдгээр санал бодлыг нийт телевиз, түүний дотор “TV9”-ийнхэн нэвтрүүлэг, хөтөлбөрийн бодлого төлөвлөлтдөө зайлшгүй анхаарвал зохилтой. Монголд өнөөдөр үйл ажиллагаа явуулж буй 100 гаруй теле суваг байна. Тэдгээрээс үндэсний хэмжээнд улс орон даяар нэвтрүүлгээ цацаж байгаа 16 телевиз байгаа. “Сант марал” сангийн судалгаанд хамрагдсан иргэдийн санал болгож буй дотоод, гадаад мэдээ мэдээллийг өдөр тутам цацаж,

улстөр, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, боловсрол, спорт, байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүх чиглэлийг хамарч иж бүрэн тал бүрийн мэдээлэл хүргэж байгаа телевиз нь харин харьцангуй цөөхөн юм. Сүүлийн жилүүдэд зөвхөн сонин, сэтгүүлүүд төдийгүй радио, телевиз, цахим сайтууд хүртэл төрөлжиж тодорхой нэг чиглэлээр дагнан мэргэших хандлага ажиглагдаж байна. Телевизийн салбарт л гэхэд “Боловсрол”, “Танин мэдэхүй”, “Соён гэгээрүүлэгч” гэх зэрэг телевиз буй болжээ. Дан ганц олон ангит киногоор голлож дагнасан “Asian box”, “Dream box” зэрэг сувгууд ч байна. Тэдгээр телевизийн хувьд бол өдөр, цаг тутмын дотоод, гадаад мэдээ мэдээлэл, хүүхэд залуусын хүмүүжил боловсролд зориулсан хөтөлбөр, Монгол Улс, монгол үндэстний түүх, соёл, шашин, ёс заншил зэрэг сэдэв нэг их сонин биш байж мэднэ. Ийм телевизүүд нь бүх нийтийг хамарсан сэдвээр үйл ажиллагаа явуулах шаардлагагүй ч байж болох юм.

Харин “TV9” телевиз бол тийм биш. Хэдийгээр үүсэн байгуулагдаад 15-хан жил болж байгаа ч гарын арван хуруунд багтах үндэсний хэмжээний цөөн хэдэн телевизийн нэг. Хүн ардын хүлээж хүсэмжилж байдаг телевиз. “Таны телевиз” гэсэн уриа дуудлага, нэршил нь үүнийг илтгэнэ. Өөрөөр хэлбэл хүн бүрт, иргэн бүрт хүрч үйлчилнэ гэсэн үг. Өнөөдөр Монголд телевизүүдийн үйл ажиллагааны үндсэн хоёр чиглэл илэрхий ажиглагдаж байгаа билээ. Нэг нь бүх нийтийн, өөрөөр хэлбэл улс нийгмийн оюуны эрэлт хэрэгцээг бүхэлд нь хангасан мэдээ мэдээлэл өгөх, нөгөө нь нийгмийн доторх тодорхой бүлэг рүү чиглэх буюу аль нэг сонирхолтой сэдвээр дагнаж ажиллах хандлага юм. Улс

орон даяар нэвтрүүлэг цацдаг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, түүний дотор “TV9” телевиз эхний хувилбараар ажиллаж байна.

Өнөөдөр “TV9” телевизэд “Энэ өглөө” залгуулаад 11.00, 15.00, 17.00, 19.30 цагт тогтмол үзүүлдэг “Энэ өдөр” хэмээх байнгын мэдээллийн хөтөлбөр байна. Мөн өдөр бүрийн 18.00 цагаас “Монгол коммент” шууд нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэж байна. Эдгээр нь Монгол Улсад болж байгаа дотоод үйл амьдралын талаарх мэдээ мэдээллийг, өөрөөр хэлбэл тус улсын нийгэм, улс-төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт зэрэг бүх салбарын амьдрал, ажил үйлсийг цаг алдалгүй, түргэн шуурхайгаар үзэгчдэд хүргэж байна. “Монгол коммент”-оор гэхэд цаг, минут тутамд цахим сайтуудад орж байгаа чухал чухал мэдээ мэдээллийг

түүвэрлэн авч, агуулгыг ард түмэндээ хүргэж чадаж байгаа учраас тэдний сэтгэлд нийцэж байдаг аж. Өөр нэг онцлог нь иргэдийн санал гомдол, шүүмжлэлийг төр засаг, яам агентлагуудын удирдлагуудад уламжилж, улмаар нийт ард түмэндээ сонордуулан дуулгаж байдаг учраас мянга мянган үзэгчидтэй байдаг юм. Хамгийн олон захидал мэдээлэл, иргэдийн сэтгэгдлийг өдөр тутам хүлээж авдаг, түүнийгээ эфирт шуурхай цацдаг редакц Монголд өнөөдөр “TV9”

телевизийн “Монгол коммент”-оос өөр байхгүй гэж хэлэхэд худал хэлсэн болохгүй.

Монголын ард түмний бүгдийнх нь танил, магадгүй олонхийнх нь хайр хүндэтгэлийг хүлээсэн сэтгүүлч бол М.Батбилэг, П.Пүрэвжаргал хоёр байж мэднэ. Иргэд итгэж найдаж байгаа учраас, “TV9” телевизийг монголчууд миний телевиз, надад тусална гэж үзэж байгаа учраас түүнд хандаж байгаа

юм. Энэ бол ХМХ-ийн хувьд хамгийн том, дээд хүндэтгэл мөн. Монголын ард түмний энэ их итгэл найдвар, хайр хүндэтгэлийг “TV9” телевиз, түүний нийт уран бүтээлчид нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж эрхэмлэн гамнаж явах үүрэгтэй.

“TV9”

телевиз өдөр бүрийн 13.00 цагаас үзүүлдэг “Гадаад мэдээ” (орой давтдаг) өөрийн гэсэн үзэгчдийн өргөн

хүрээлэлтэйг тэмдэглэж хэлье. Энэ бол уг хөтөлбөрийг бодож боловсруулж үзэгчиддээ өргөн барьдаг олон улсын тоймч Ш.Гантулгын арга ажиллагаа, арвин туршлагатай шууд холбоотой. Дэлхий дахинаа гадаадын улс орнуудад өрнөж буй үйл явдлыг түүх судлал, олон улсын үйл амьдралын гүн гүнзгий мэдлэгтэйгээр тал бүрээс нь задлан шинжилж ямар үйл явдал хаана болов, яагаад ингэхэд хүрэв, цаашдын үр дагавар нь юу болох хэмээн өргөн хүрээнд нээн үзүүлж байдгаараа “TV9”



Монголд телевизүүдийн үйл ажиллагааны үндсэн хоёр чиглэл илэрхий ажиглагдаж байгаа билээ. Нэг нь бүх нийтийн, өөрөөр хэлбэл улс нийгмийн оюуны эрэлт хэрэгцээг бүхэлд нь хангасан мэдээ мэдээлэл өгөх, нөгөө нь нийгмийн доторх тодорхой бүлэг рүү чиглэх буюу аль нэг сонирхолтой сэд-вээр дагнаж ажиллах хандлага юм. Улс орон даяар нэвтрүүлэг цацдаг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, түүний дотор “TV9” телевиз эхний хувилбараар ажиллаж байна



телевизийн гадаад мэдээ хүмүүст илүү итгэл үнэмшилтэй сонсогддог. Өөр нэг онцлог нь уг үйл явдлыг Монголын нийгмийн амьдрал, улс төр, эдийн засгийн байдалтай холбон тайлбарлаж монгол хөрсөн дээр ойлгомжтойгоор буулган нутагшуулж сургамж сэрэмжлүүлэг өгч байдгаараа олон улсын тоймч Ш.Гантулгын бэлтгэсэн гадаад мэдээ мэдээлэл илүү амт шимттэй байдаг юм. Өнөөдөр монголын нийгэмд түүний мэдээ мэдээллийг хүсэмжлэн хүлээж байдаг бүхэл бүтэн нийгмийн давхарга буй болсон байна. Энэ бол “TV9” телевизийн үйл ажиллагааны нэг үнэт зүйл мөн.

Эдгээрээс гадна “TV9” телевизийн хөтөлбөр төлөвлөлтийн бодлогод байнгын баттай байр суурь эзэлсээр ирсэн “Ардын парламент”, “Ярилцъя л даа”, “Үйл явдал, сургамж”, “Эзэнгүй төрийн эмгэнэл”, “Хасах градус”, “Дотно сэдэв”, “Энэ өдрийн зочин”, цаг үеийн үйл явдлын талаарх “Тодруулга” булан үзэгчдийн сонирхлыг ихэд татаж байна.

“Мөрөөдөл биелдэг юм”, “АХА”, “Зүүд биш л байгаа даа”, “Танайд мод тарья”, “Будда продакшн”, “Гялайлаа” нэвтрүүлэг “TV9” телевизийн дэлгэцнээ тогтмол гарч байна. Олон ч үзэгчидтэй болжээ. “Би өөрөө гоо сайхан буюу Монгол Let me in”, “Буурал түүхийн жимээр”, “Туурвихуйн урланд”, “Нэрийн хуудас”, “Эгэл эмэгтэй” зэрэг хөтөлбөр монголын үзэгчдийн танил нэвтрүүлэг, хүсэн хүлээдэг хөтөлбөр болж хувирчээ.

Авьяаслаг хүүхэд багачуудыг дэмждэг “Гэгээн алсын одод” хүүхдийн урлагийн их наадам эсгий туургатан монгол үндэстний авъяаслаг хүүхдүүдийн олон улсын арга хэмжээ болж өргөжин гүнзгийрээд байна. Энэхүү наадамд Буриад, Халимаг, Өвөр

Монголын хүүхдүүд өргөнөөр хамрагддаг боллоо. “Гэгээн алсын одод” олон улсын урлагийн их наадамд оролцогчдоос ирээдүйн одод төрөн гарна гэдэгт бид итгэлтэй байдаг.

Эгэл жирийн атлаа эгэлгүй баатарлаг сайн сайхан үйлсийг бүтээдэг, хэнд ч үл мэдэгдэх жирийн, хөдөлмөрийн хүнийг магтан дуулдаг “TV9” телевизийн “Энэ цагийн эгэл баатар” нэвтрүүлгийг өнөөдөр мэддэггүй хүн байхгүй болжээ. Энэ бол агуулгын хувьд манай “Хөдөлмөрийн баатруудаа сайн байцгаана уу” хэмээх алдарт шууд нэвтрүүлгийн нэг хувилбар нь юм. Үзэгч олон түмэнд санаа авахуулах, бодол эргэцүүлэлд хөтөлж ухааруулах, хөдөлмөр тэмцлийн сайн үйлсээр хүмүүжүүлэх зүйлээр уг нэвтрүүлэг элбэг баян байдаг гол онцлог нь байгаа юм. Маш чухал ач холбогдолтой нэвтрүүлэг юм.

“TV9” телевизийн үйл ажиллагааны өөр нэг үндсэн чиглэл бол бүх нийтийн биеийн тамир, спортын шууд нэвтрүүлгүүд байдаг билээ. Бүр үүсэн байгуулагдах цагаасаа эхлэн цагаан сар, үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдааныг шууд дамжуулан үзэгчиддээ хүргэж иржээ. Хурдан морьдын уралдаан, эрхий мэргэн харваачид, шагайн харвааны уралдаан тэмцээн бол тус телевизийн байнга дамжуулдаг гол сэдэв. Монголын үндэсний бөхийн өргөөнд бямба, ням гариг бүрт байнга болдог хүчит бөхийн барилдааныг үүн дээр бас нэмж нэрлэх хэрэгтэй. “Даншиг наадам-Хүрээ цам”-ыг гэхэд тасралтгүй шууд дамжуулж байна. Эдгээр нь сүүлийн жилүүдэд аймаг, сумдын тэмдэглэлт ойн баяр наадмуудын шууд дамжуулалтаар өргөжин баяжиж байна. Дэлхийн хэмжээний болон олон улсын спортын уралдаан тэмцээн ч мөн ялгаагүй тус

телевизийн нэвтрүүлгийн бодлогын төвд оршиж байгаа.

“TV9” телевизийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг, өөрөөр хэлбэл хөтөлбөрүүдийг агуулгын хувьд ангийн сэдэвчилж нэгтгэж үзэх юм бол **нэгд**, дотоод гадаадын мэдээ мэдээлэл (“Энэ өглөө”, “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөр, Гадаад мэдээ, ням гаригийн “Анализ” буюу долоо хоногийн үйл явдлын тойм, орон нутгийн мэдээ (Инфо сүлжээ), **хоёрт**, нийгэм-улстөрийн нэвтрүүлгүүд (“Ардын парламент”, “Монгол коммент”, “Ярилцъя л даа”, “Үйл явдал, сургамж”, “Хасах градус”, үйл явдлын “Тодруулга”, “Эзэнгүй төрийн эмгэнэл”, “Энэ өдрийн зочин” зэрэг), **гуравт**, үндэсний хэл соёл, ёс заншил, түүх уламжлал, шашин, соён гэгээрэхүй (“Эх хэлээ эрхэмлэн дээдэлъе”, “Буддизм бидний амьдралд”, “Ном хурах цаг”, “Би монгол хүн”, “Таны жинхэнэ орон гэр”, “Зулын 25”, “Зулын 15” зэрэг), **дөрөвт**, биеийн тамир, спорт (Цагаан сар, Үндсэн хуулийн ба Тусгаар тогтнолын өдөр, Үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдаан, хурдан морьдын уралдаан, эрхий мэргэн харваачдын тэмцээний шууд дамжуулалт, бямба, ням гариг бүр монголын үндэсний бөхийн өргөөнөөс үзүүлдэг хүчит бөхийн шууд дамжуулалт, үндэсний баяр наадмын болон бүсүүдийн их хурдын уралдаан, аймаг, сумдын тэгш тэмдэглэлт ойн наадмууд, TV9 спорт цуврал), **тавд**, танин мэдэхүйн чиглэлийн хөтөлбөрүүд (“Аян замын тэмдэглэл”, “Туурвихуйн урланд”, “Домгийн мөрөөр”, “Авто мастер”, “Айлын хоол амттай”, “Авто мастер”, “Эрүүл мэнд” теле сэтгүүл зэрэг), **зургаад**, хүүхэд, өсвөр насныханд зориулсан цуврал нэвтрүүлэг (“Гэгээн алсын одод”, “Лоолойгийн найзууд”, “Хүүхэд

шуугисан их өргөөний эзэд”, “Сэтгэлийн чимэгтэй хүүхэд нас”, “Ухаалаг найз”, хүүхэлдэйн цуврал кино анимейшн зэрэг), **долоод**, зугаацуулан цэнгүүлэх хөгжөөнт нэвтрүүлгүүд (“Мөрөөдөл биелдэг юм”, “АХА”, “Хөдөлмөрийн баатруудаа, сайн байцгаана уу”, “Би өөрөө гоо сайхан буюу Монгол Let me in”, “Гэр бүл (Challenge), After School club, “Цэрэг эх оронч хүмүүжил”, “Монгол нутгийн гоо үзэсгэлэн” цуврал зураглал”), **наймд**, дуу хөгжмийн хөтөлбөрүүд (“Үдшийн аялгуу”, “TV караоке”, “Хөгжмийн завсарлага”, “Ая дууны мэндчилгээ”, “Урлагийн мастеруудын цуврал концерт”, “Баяр наадмын уянга” зэрэг), **есөд**, дотоод гадаадын уран сайхны болон баримтат кинонууд (монголын болон гадаадын улс орнуудын урт богино кино), **аравт**, арилжааны зориулалттай нэвтрүүлгүүд (“ТВ зууч 1900-1913”, “Бизнес максимум зэрэг”) гэж хувааж үзэж болохоор байна.

Арилжааны чөлөөт телевизүүд, түүний дотор “TV9” телевизийн аялгарах гол онцлог бол улсаас хөрөнгө санхүүгийн ямар нэгэн дэмжлэг авдаггүй бөгөөд өөрөө өөрийгөө ашигт үйл ажиллагаагаараа санхүүжүүлдэгт оршдог билээ. Энэ бол зах зээлийн эдийн засгийн харилцааны үндсэн гол зарчим юм. Хэрэв МҮОНРТ-д улсаас олгодог шиг хөрөнгө санхүүгийн тодорхой дэмжлэг байдаг бол, телевиз үзэгч айл өрхүүдээс төлдөг хураамжийн нэг хэсгийг чөлөөт телевизүүдийн нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг хариуцлагыг нь үнэлэн үзэж тэдэнд зохих хэмжээгээр олгож хуваарилдаг байсан бол нэвтрүүлэг хөтөлбөрүүдийг баяжуулан өргөжүүлэх шинэ шинэ бололцоо нээгдэх нь ойлгомжтой юм. УИХ-д боловсруулагдаж батлагдахаар хүлээгдэж байгаа

Өргөн нэвтрүүлгийн программын тухай хуульд үүнийг тусгах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйл ажиллагаа нь сэтгүүлч, редактор, найруулагч, зураглаач, инженер-техникийн ажилтнуудын нэгэн зорилгот нэгдмэл үйл ажиллагааг, ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөрийг нэхэн шаарддаг нүсэр том бөгөөд тасралтгүй үргэлжлэх, мэдээлэл боловсруулж үйлдвэрлэх үйл ажиллагаа юм. Өндөр дээд зохион байгуулалт, өргөн дэлгэр мэдлэг боловсрол, мэргэжлийн нарийн ур чадвар, шинжлэх ухааны гүн гүнзгий үндэслэлтэй төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг шаардана. Нэг хүнээс буюу өндөр зэрэглэлийн уран бүтээлчээс хамаарах үүрэг ролийг үгүйсгэж болохгүй ч хамгийн гол нь хамтын хүчин чармайлтын үр дүнд сая бүтэж бүрэлдэж буй болдог. Телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөр бүр нь хамтын үйл ажиллагаа, хамтын оюун санааны үр дүнд буй болсон хамтын бүтээл байдаг өвөрмөц онцлогтой. Өөрөөр хэлбэл тухайн телевизийн уран бүтээлч нийт хамт олны оролцоог шаардсан нэгдмэл бүтээл, дуу авиа, дүрс бичлэг, зохиол сценари хийгээд техникийн өвөрмөц шийдлийн хосолмол урлаг юм.

Монголын цөөнгүй телевиз, түүний дотор “TV9” телевизийн үйл ажиллагаанд сүүлийн үед хүчтэй нэвтэрч буй нэг сонирхолтой чиглэл нь үзэсгэлэнт Монгол орны өнцөг булан бүр –Говь, Хангай, Алтай, Монголын тал хээр нутгийн унаган дүр төрх, давтагдашгүй онгон зэрлэг байгаль орчин, ан амьтан, араатан жигүүртний ертөнцийг мэргэжлийн өндөр түвшинд харуулсан теле зураглал юм. Энэ бол телевизийн үйл ажиллагааны ирээдүйтэй нэг чиглэл мөн гэдэг нь тод мэдрэгдэж байгаа

бөгөөд гэрэл зурагчин Ганбаяр, сэтгүүлч М.Буянбадрах нарын “Хүрээлэн” цуврал үзэгчдийн сэтгэл зүрхийг соронздон татаж байгаа нь үүний нотолгоо болно.

“TV9” телевизийн зураглаач Г.Орлонжав нь байгалийн зураглалаар гаршиж яваа авьяаслаг залуу уран бүтээлчийн нэг юм. Түүний “Таван эрдэнэ” /Сэлэнгэ нутаг, 2011/, “Тамирын гол” /Архангай, 2011/, “Чулуутын хавцал” /Архангай, 2013/, “Булган хангай” /2014/, “Баянзаг” /Өмнөговь, 2014/, “Жимсэн төгөл” /Ховд аймгийн Булган сум, 2014/, “Ганга нуур” /Сүхбаатар, 2014/, “Цэцэг нуур” /Ховд, 2015/, “Бурхан Халдун уул” /Хэнтий, 2017/, “Хоргын тогоо” /Архангай, 2018/ зэрэг зураглал үзэгчдийн сэтгэл зүрхэнд нийцсэн сайн бүтээл болсон билээ. Зураглаач Я.Алтангэрэлийн “Хадан авиралт” /2016/, “Мөсөн авиралт” /2014/, “Хөвсгөл далай” /2016/, “Хэнтийн Дадал сум”, зураглаач Г.Нацагдоржийн “Бороо”/2015/, “Дөрвөн улирал” /2017/, “Өвөл” /2018/ уран зураглал ч сонирхолтой бүтээл болж чадсан юм. Энэ бол “TV9” телевизийн ахмад зураглаач, МУСГЗ Б.Донровын шавь нар нь уран бүтээлийн олз омог ихтэй байгаагийн бодит жишээ юм.

Эдгээрээс харахад хүн амын төвлөрөл, хотжилт өсөн нэмэгдэж байгаа өнөө цаг үед хүрээлэн байгаа байгаль орчны талаарх теле зураглалын ач холбогдол, үзэгчдийг өөртөө татах хүч увидас улам бүр өсөн нэмэгдэх чиг хандлагатай нь ажиглагдаж байна. Танин мэдүүлж, соён гэгээрүүлэх үйлсэд шууд үйлчилж буй телевизийн уран зохиомж, дүрслэлт теле уран уншлага ч телевизийн уран бүтээлүүдэд чухал үүрэг гүйцэтгэж утга төгс чимэглэл болж байгааг “TV9” телевизийн нэвтрүүлэгч, МУСТА

Л.Эрдэнэбаатарын “Эх хэлээ эрхэмлэн дээдэлье”, “Зугаацахаар мордсон нь”, “Эхийн сэтгэл”, “Үрдээ бичсэн шүлэг”, “Гурамсан сүлжээ” сургаал зэрэг уран уншлагат зохиомжоос харж болно. Теле урлагт нэвтрүүлэгч хэмээх хосгүй ховорхон мэргэжил бий. Өнөөдрийн “TV9” телевизийн өнгө царайг Мэргэний Ундрам хэмээх жинхэнэ монгол нүүрийн баясгалантай, тайз дэлгэцийн урлаг, эфирийн соёлыг төгс эзэмшсэн, тал бүрийн өндөр боловсрол, түүний дотор гадаад хэлний өндөр мэдлэгтэй бүсгүйгүйгээр төсөөлөхөд бэрх юм.

Дэлхий дахин, олон улсын практикт шинжлэх ухаан, техникийн хамгийн сүүлийн үеийн ололт амжилтыг теле салбарт өргөнөөр нэвтрүүлэх болсноор телевизийн нэвтрүүлгүүдийн дуу чимээ, дүрс бичлэгт чанарын хувьсал гарч үзэгчдийг гайхшруулан теле хөтөлбөрүүдийн нэр төрөл олширч, цаг мөчтэй уралдан улам бүр боловсронгуй болон шинэчлэгдэж байна. Үүний нэг тод илрэл бол шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлийн теле хөдөлгөөнт дүрслэлүүд, зохиомжит нэвтрүүлгүүд, хүүхэлдэйн кино цувралд гарч байгаа өөрчлөлт шинэчлэл юм. Телевизийн урлагийн график дизайн хөгжлийн цоо шинэ өндөрлөгт гарчээ.

“TV9” телевизийн график дизайнч Н.Амарбаярын бүтээсэн “Гоёо гоёо” /2008/, “Цодгор хүү” /2010/, шинэ жилийн сэдэвт “Гацуур мод”, “Баярын салют” /2016/, “Цагаан сар”, “Золголт” /2017/, үндэсний баяр наадмын сэдэвт “Хүчит бөх”, “Хурдан морьд”, “Эрхий мэргэн”, “Шагайн харваа” /2017/ анимэйшн, Н.Амарбаяр, Энхболор нарын хамтран бүтээсэн “Бүнээ, Сүнээ хоёр” танин мэдэхүйн 9 ангит цуврал хүүхэлдэйн анимэйшн кино тус

телевизийн үйл ажиллагааны түүхэнд уран бүтээлийн шинэ хуудсыг нээж буйг үнэлэн тэмдэглэвэл зохилтой.

“TV9” телевизийн уран бүтээлч хамт олон сүүлийн үед Т.Баасансүрэнгийн “Сумын эмч” уран сайхны 7 ангит кино, “Их Монгол Улс” 2 ангит теле нийтлэл, “МАХН-монголын улстөрийн гурван том хүчний нэг” хоёр хэсэгт телевизийн нэвтрүүлэг зэрэг шинэ шинэ уран бүтээл туурвижээ. Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч, МАХН-ын дарга Н.Энхбаяр 2010-аад онд “Буурал түүхийн жимээр” хэмээх танин мэдэхүйн цувралыг санаачилж эхлүүлсэн байдаг. 2018 онд гэхэд уг цувралын хүрээнд Бурхан Халдун ууланд хийсэн морин аялал, “Монголын нууц товчоо”-нд нэг бус удаа дурдагддаг Гурван голын сав газарт түүх судлаач эрдэмтдийн зохион байгуулсан тойрон аяллаар сонирхолтой нэвтрүүлгүүд бэлтгэж үзэгчиддээ өргөн барьсан байна. Эдгээрээс харахад МУСГЗ, ахмад найруулагч О.Соёлтын ажлын арвин их туршлагыг залуу үеийнхэн үйл ажиллагаандаа амжилттай өвлөн авч үргэлжлүүлж шинэ утга агуулгаар баяжуулж байгаа нь тод харагддаг. Өсч яваа тийм залуу найруулагчийн нэг бол Б.Шинэхүү юм. Тус телевизийн залуу уран бүтээлчид бүтээл туурвилаар арвин байна.

“TV9” телевизийн өнгөрсөн 15 жилийн үйл ажиллагааны түүхэн замнал дандаа дардан шулуун байгаагүй. Унаж босох, урагшлах зогсохын аль алийг даван туулж өсч хөгжсөөр өнөөдрийг хүргэсэн гэж хэлж болно. Үүсгэн байгуулагчийг нь улстөрийн тавцангаас ямар ч арга замаар хамаагүй бүрмөсөн зайлуулж замаа цэвэрлэхийг хүсэмжлэн мөрөөдсөн

МАНАН-гийн олигархи бүлэглэлийнхэн Намбарын Энхбаярыг баривчлан шоронд хорьж, “TV9” телевиз, “Зууны мэдээ” сониныг Монголын нийгэм дэх могойн хортой адилтгаж нэгэн мэргэн мэдэмхийрэгчийн хэлж зөвлөж анхааруулснаар хорт ургамлын үзүүр оройг тасдах биш үндсээр нь ухаж сугалж хаях хэрэгтэйг хэрэгжүүлэх гэж санаархаж зүйл бүрээр хавчин гадуурхаж байсан он цаг өчигдөрхнийх. Тэдний задлан бутаргах санаархал, өдөлт турхилтаар “TV9” телевизийн 43 уран бүтээлч хэвлэлийн бага хурал хийж сүржин мэдэгдэл хийгээд төрөлх гал голомтынхоо үнсийг самарч, үүдийг хаялан гарч явж байсан нь ч бас л саяхных. Ийм бодит бэрхшээл, улстөрийн хатуу ширүүн хавчилт шахалт Монголын өөр нэг ч телевизэд тохиолдоогүй юм. Засгийн эрх баригчдын тэрхүү утопи санаархал өнөөдөр ч амь бөхтэй оршсоор байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн санал хураалт болохоос дөрөвхөн хоногийн өмнө Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газраас “TV9” телевизийн үйл ажиллагааг 4 хоногоор түр түдгэлзүүлэх хууль бус шийдвэр гаргаж байсан нь үүний нэг нотолгоо юм.

Тэр хүнд бэрх цаг үед тус телевизийн захирлаар ажиллаж байсан Ц.Энхбат Японы нэгэн шашны байгууллагаас бэлэглэсэн гэж хэл ам дагуулсан телевизийн студийн хэдэн камер, техник хэрэгслийг эргүүлж өгөхөөр багцлан боож сониучирхан үзэхэд мэргэжлийн гэж хэлэхэд хэцүүхэн, харин сонирхогчдын хэмжээний л зүйл байсан юм билээ гэж ярьж байсныг санаж байна. Түүнийг “TV9” телевизээс явсны дараа гал голомтоо сахиж үлдсэн Н.Долгор захирал янз

бүрийн юмтай нүүр тулж, гэв гэнэтхэн өндөр зэрэглэлийн голлох мэргэжилтнүүдээ алдаад гар мухардаж суухад нь ихэд өрөвдөж сэтгэлийн дэм үзүүлж явснаа ч мартаагүй байна. Сүүлд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын захиалгат шударга бус “араанд зуугдаж” телевизийн үйл ажиллагаагаа түдгэлзүүлэх дүгнэлт гаргуулчихаад ХХЗХ-ны дарга, орлогч нартай уулзан заргалдаж нэг үзэж, тайлбарлаж нэг үзэн үнэнийг ойлгуулах гэж хичээж суухдаа “Шаварт унасан шарын эзэн”-ий зовлонг бие сэтгэлээрээ өөрөө амсаж явлаа. Техник хэрэгслийн хомсдол хоцрогдол, мэргэжлийн боловсон хүчний дутагдал, улстөрчдийн эрээ цээргүй хавчилт шахалт, эрх баригчдын захиалгат явуулга—энэ бүхэн бол “TV9” телевиз, түүний хамт олонд тохиолдсон, өсөлт хөгжилтийн явцад нь тулгарсан хүнд бэрх сорилт, орших уу эс оршихуйдаа тулсан чөлөөт хэвлэл мэдээллийн төлөөх тэмцэл, тэсвэрлэж үлдэхийн тулд хамт олноороо үнэнхүү чармайж ажилласан он сарууд байсан юм. Тухайн цаг үед бидний өөрсдийн эвлэлдэн нэгдсэн мэргэжлийн гэх тодотголтой –МСНЭ хүртэл маниасаа нүүр буруулж байсан гэж хэлбэл өнөөдөр олон хүн үнэмшихгүй л болов уу. Гэвч бодит байдал тийм л байсан бөгөөд мартаж болохгүй гашуун сургамж болж үлдсэн билээ.

Эдүгээгээс 5 жилийн өмнө миний бие “TV9” телевизийн 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд “TV9” телевизийн нэвтрүүлгүүдийн байдалд хийсэн зарим ажиглалт, үнэлэлт дүгнэлт, практик зөвлөмж” гэсэн илтгэл тавин хэлэлцүүлж байв. Тэр үед би тус телевизийн Уран сайхны зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан. Илтгэлд “TV9” телевиз өөрийн

түүхэнд тохиосон хамгийн хүнд бэрх цаг үе буюу хямралын зурвасыг туулж, түүнийг давж гарч чадахаар байгаа нь өнөөдөр нэгэнт тодорхой харагдаж байна. Энэ маш чухал юм. Ийм хүнд бэрх сорилт монголын бусад нэг ч телевизэд тохиолдоогүйг тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу” гэсэн нэгэн дүгнэлт хийжээ. Уг дүгнэлт үнэн болохыг өнгөрсөн 5 жилийн туршлага баталсан гэж хэлж болно.

“Т“TV9” телевизийн өнгөрсөн 15 жилийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийж, шинжлэн тоймлож, тодорхойлон томъёолж хэлэх юм бол:

Нэгд, “TV9” телевиз нь Монголын ОНМХ-ийн системд чухал байр суурь эзэлж байгаа телевизийн салбарт өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрх, дуу хоолойтой, үйл ажиллагааны тов тодорхой чиглэл бүхий чөлөөт телевиз болон төлөвшиж байна. Чөлөөт хэвлэл мэдээлэл нь ардчилсан нийгэм, түүний үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх юугаар ч сольшгүй үнэт хэрэгсэл юм.

Хоёрт, нэр хүндтэй судалгааны байгууллагуудын удаа дараагийн социологийн судалгаанаас харахад “TV9” телевиз монголын үзэгчдийн дурлан үздэг телевизийн нэг болж чаджээ. Тус телевиз нь үзэгчдийг өөртөө татаж чадаж байгаа тэргүүлэх топ 10 телевизийн нэг, олон нэвтрүүлэг хөтөлбөрөөрөө топ 5 телевизэд зүй ёсоор тооцогдож байна. Энэ бол үүсэн байгуулагдаад 15 жил болж байгаа “Таны телевиз TV9”-ийн нийгэмд үзүүлж байгаа үр өгөөж, нэвтрүүлэг хөтөлбөрүүдийн үр нөлөө өндөр түвшинд байгааг илтгэж буй гол үзүүлэлт мөн.

Гуравт, энэ бүгд нь “TV9” телевизийн программ төлөвлөлт

шинжлэх ухааны үндэслэлтэй, үндэсний контент үйлдвэрлэл нь зөв чиг гольдрилоор явж байгааг илтгэн харуулж байна. Ингэхдээ гадаад хэлийг буруу зөрүү хэрэглэхээс зайлсхийж, ажилтнуудынхаа эх хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд онцгой анхаарч монгол хэлний мэргэжлийн зөвлөхийг ажиллуулж буй нь үйл ажиллагааны санаа авууштай сайн туршлага болно.

Дөрөвт, “TV9” телевизэд бусад теле сувгуудад байхгүй өөрийн гэсэн нэг өвөрмөц онцлог байна. Энэ нь монголын ард түмний үндэсний амин чухал эрх ашгийг тэргүүн байранд тавьж, түүнийг өмгөөлж хамгаалах гуйвшгүй шинж чанар, зарчимч байр суурь нь юм. Төр засаг, эрх баригчдын хуудуутай үйл ажиллагаа, хүнд суртлыг хурцаар шүүмжилж олон нийтийн хяналтад оруулах, МАНАН-гийн олигархи бүлэглэл, оффшорчдын үнэн нүүр царай, улстөрчдийн хөшигний цаадах луйвар булхай, хуйвалдааныг илчилж ил тод болгоход “TV9” телевиз өөрийн хувь нэмрийг хамгийн идэвхтэйгээр оруулж чадаж байна. Монголын нийгэм дэх цөөнхийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж нэг бус тохиолдолд сөрөг хүчний дуу хоолой болж, чөлөөт хэвлэлийн үндсэн зарчимд үнэнч байгаа учраас иргэд үзэгчид “TV9” телевизэд итгэж найддаг, хамгаас түрүүлж түүнд ханддаг болжээ.

Тавд, ололт амжилтаа бататгаж, алдаа дутагдлаа арилгах чиглэлээр санаачилга гарган ажиллаж, энэ нь тус телевизийн үйл ажиллагаанд хэвшил болж байгаа нь тод харагдаж байна. Энэ бол зөв чиг хандлага мөн. Гэхдээ дээр дурдсан бүхэн нь “TV9”-ийн үйл ажиллагаа, нэвтрүүлэг хөтөлбөрүүдэд

дутагдал доголдол огт алга гэсэн үг хараахан биш юм.

Энэ бүхнийг иш үндэс болгож “TV9” телевизийн цаашдын үйл ажиллагаанд санаа авахуулах үүднээс дор дурдсан цөөн хэдэн практик зөвлөмжийг Медиа Холдинг ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, “TV9” телевизийн Захирлын зөвлөл болоод Уран сайхны зөвлөлд санал болгож байна. Үүнд:

1. Өнгөрсөн 15 жилийн үйл ажиллагааны үр дүнд хуримтлагдаж, тус телевизийн үе үеийнхний хөдөлмөр зүтгэлийн үр дүнд буй болсон давуу талаа гүйцэд ашиглах замаар улам баяжуулан гүнзгийрүүлж цаг ямагт хувьсан өөрчлөгдөж шинэчлэгдэхийг эрхэмлэж шинэлэг сэтгэлгээгээр ажиллаж хөдөлмөрлөх. Тэргүүн ээлжинд:

-Үйл ажиллагааны өнөөгийн үндсэн чиглэл, чөлөөт хэвлэлийн үндсэн зарчимдаа үнэнч байж ардчилсан нийгэм, түүний үнэт зүйлсийн манаач, сөрөг хүчний дуу хоолой болсоор байх.

-Үндэсний контент үйлдвэрлэлээ өргөжүүлж олон ангит цуврал кино бүтээх, монголын ард түмний түүх соёл, зан заншил, нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг сурталчилсан нэвтрүүлгүүд, хүүхэд залуусын хүсэл эрмэлзэлд нийцсэн танин мэдэхүй, соён гэгээрэхүй хийгээд эх оронч үзлийг эрхэмлэсэн хөтөлбөрүүдийн тоо хэмжээг улам нэмэгдүүлэх.

-Хүчит бөхийн барилдаан, хурдан морьдын уралдаан, нум сум, шагайн харваан шууд дамжуулалт, аймаг, сумдын түүхэн тэмдэглэлт баяр наадмын үзүүлбэрүүдээ улам төгс боловсронгуй болгон үргэлжлүүлэх.

2. Үйл ажиллагаандаа оршиж байгаа сул талд үнэн зөв үнэлэлт дүгнэлт хийж, дутагдал доголдлыг арилгах

чиглэлээр эрчимтэй бөгөөд тууштай ажиллах. Тухайлбал:

-Чадварлаг мэргэжлийн уран бүтээлчдээр телевизээ бэхжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж сэтгүүлч-зураглаач-найруулагч-инженер техникийн ажилтнуудын гар, сэтгэл нийлсэн хамтын ажиллагааг хангаж ажиллах, тэдний тогтвор суурьшилд онцгойлон анхаарч мэдлэг мэргэжлийг нь байнга дээшлүүлэх. Сүүлийн жилүүдэд хувийн теле-визүүдэд нийтлэг ажиглагдаж байгаа ар өврийн хаалгаар ажилд авах, ах дүү төрөл саднаа бөөгнүүлэх, авьяас чадварыг үл ойшоох, ардчилсан хамтын удирдлагыг огоорох зэрэг дутагдлаас ангид ажиллах явдал нэн чухал юм.

-Телевизийн техник технологийн шинэчлэлийг хэтийн болон ойрын зорилтот хөтөлбөрийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх. Хувийн чөлөөт телевизүүдэд тохиолдож буй хамгийн гол бэрхшээлийн нэг нь энэ. Хэдий тийм боловч мэдээллийн өнөөгийн эрин цаг үед шинжлэх ухаан, техникийн хөгжил дэвшил бүхнийг шийдвэрлэж байгааг мартаж болохгүй.

-Бусад телевиз, ялангуяа АНУ, ОХУ, Япон, Солонгос зэрэг үйлс зорилго нэгт гадаадын телевизүүдийн үйл ажиллагааны туршлагаас тасралтгүй бүтээлчээр суралцах.

Хөрш зэргэлдээх улс гүрэн – ОХУ, БНХАУ, Буриад, Халимаг, Тува, ӨМӨЗО-ны үндэсний телевизүүдээс эхлээд гурав дахь хөрш-хөгжингүй улс орнуудын телевизийн сувгуудтай ажил төрлийн холбоо тогтоож ажиллах, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь дэлхий нийтийг хамран өрнөж буй даяарчлалтай хөл нийлүүлж амжилттай урагшлахын нэг угтвар нөхцөл болно.

-Телевиз үзэгчдийн социологийн судалгааны үр дүнд байнгын анализ хийж үйл ажиллагааныхаа эерэг талыг бэхжүүлж, сөрөг сул талыг арилгаж ажиллах. Үзэгчдийн сонирхолд нийцүүлж нэвтрүүлэг хөтөлбөр бэлтгэх, тэдэнд зориулсан контент үйлдвэрлэж байж сая зах зээлийн ширүүн өрсөлдөөнд ялж гарах болно.

-Үзэгчдийг хөгжөөн цэнгүүлэхэд чиглэсэн теле хөтөлбөрийн тусгай бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж, гадаадын улс орнуудаас худалдан авдаг олон ангит киноны чанарт өөрчлөлт шинэчлэл гаргах. Сүүлийн үед “Монгол” телевиз “Авьяаслаг монголчууд”, “Боловсрол” телевиз “Яг түүн шиг”, “25-р суваг” телевиз “Монгол, Солонгост нэг удаа”, “TV5” телевиз “Оддын бэсрэг наадам”, NTV “Ахлах тогоочийн заавраар” зэрэг үзэгчдийн сонирхол татсан зугаацуулах нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байгаа нь гарцаа байхгүй амжилт дагуулж байна.

-“TV9” телевизийн мэдээ мэдээллийн шуурхай байдалд онцгой ач холбогдол өгч, агуулга зохиомжид нь чанарын хувьсал хийх, ням гаригийн “Анализ” нэвтрүүлгийн чанарыг дээшлүүлэх. Мэдээ мэдээллийн зохиомж, багтаамж, чанар, шуурхай байдлаараа өнөөдөр МҮОНТ тэргүүлж яваа, “TV9” телевиз улсын хэмжээнд үзэгчдийнхээ тоо хэмжээгээр хоёрт орж байгаа ч энэ чиглэлээр бодож бясалгах, боловсронгуй болгон сайжруулах ажил цөөнгүй байна.

Ишлэл

- ¹ ХХЗГ-аас 2013 онд 21 аймагт явуулсан тандалт судалгаа
- ² Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн 2012-2014 оны судалгааны тайлан.
- ³ “Сант Марал” сангаас 2017 оны 3-р сард явуулсан “Монголчуудын хэвлэл

мэдээлэлд хандах хандлагын үр дүн, судалгаа”.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2016. Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна. УБ.
2. Баасансүрэн Т. Ард Аюушийн хөдөлгөөнийг арай өөр өнцгөөс харах юм бол... УБ.
3. Зулькафиль М. 2014. Сэтгүүлчийн мэргэжил: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
4. Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
5. “Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ. 2012-2014 оны судалгааны тайлан.
6. “МАКСИМА” судлагааны компани. 2013-2018 оны цуврал судалгаа.
7. “Сант Марал” сан. “Монголчуудын хэвлэл мэдээлэлд хандах хандлагын үр дүн, судалгаа”.
8. “TV9” телевиз-Таны телевиз. УБ. 2015.
9. ХХЗГ. 2013. 21 аймагт явуулсан тандалт судалгаа

Резюме

В данной статье автор классифицирует программы “TV9” по тематике и опираясь на факты показывает их влияние на общественное сознание. Автор подтверждает свои изыскания сравнительным анализом результатов опросов телезрителей Институтом прессы Монголии, исследовательской компанией “МАКСИМА” и фондом “Сант-Марал”. Также используется исследование, проведённое Комитетом связей по регулированию коммуникаций среди телезрителей 21 аймаков Монголии. Особый акцент придаётся описанию деятельности, трудностей, достижений и уроков “TV9” за последние 15 лет. Особая ценность данной статьи состоит в том, что автор показывает тенденцию становления и развития свободной демократической прессы в Монголии за прошедшие 30 лет на реальном примере деятельности телевизионного канала “TV9”.